

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ШИНЭЛЭГ АЖЛЫН МЭДЭЭ

2024.06.18

Мандалговь хот

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 сарын 15-ны өдрийн А/136 дугаар тушаалын дагуу баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг, ангилалт хийх, хянан баталгаажуулаж ажлын хүрээнд Хулд таван эрдэнэ ХХК мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж нь Олдохын хүрэн бор омгийн тэмээнд үзлэг ангилалт, хянан баталгаажилтыг хийсэн.



2.Аймгийн үхэр сүргийг үе шаттайгаар сайжруулах ажлын хүрээнд Баянжаргалан сумын ЗДТГазартай хамтран 2021 оноос Дорнод аймгийн Халх гол суманд үржүүлэгддэг махны чиглэлийн Дорнод монголын мухар улаан үүлдрийн хээлтүүлэгчийг сайжруулагчаар ашиглагдаж байгаа бөгөөд энэ оноос гарсан төлөөс нь өсвөр 10 хээлтүүлэгч бойжуулахаар сонгон шилэн сонгох ажлыг зохион байгуулсан.



3.Дорнод аймгийн Халхгол сумаас 6 хээлтүүлэгчийг орон нутагт шинээр авчирч сайжруулагчаар ашиглахаар болоод байна.



4. Олон улсын төсөл хөтөлбөрт хүсэлт тавьсаны дагуу Биологийн хүрээлэн, Хөх хотын тариалангийн их сургуультай хамтарсан тэмээний сүүлнээс генетик тодорхойлох судалгааны ажлаар олдохын хүрэн бор омгийн тэмээнээс дээжийг авлаа.



5. Малын үзлэг ангилалтын дэвтэр боловсруулж гаргасан бөгөөд цөм сүргийн малчин өрхүүдэд үзлэг ангилалтыг хийж баталгаажуулан бичилт хийж өгөх зорилготой боловсруулсан.

НУТГИЙН БОЛОН БАТАЛГААЖСАН ҮҮЛДЭР, ОМГИЙН МАЛД ҮЗЛЭГ АНГИЛАЛТ ХИЙСЭН БҮРТГЭЛИЙН ДЭВТЭР

Бүртгэлийн дугаар:
Аймаг:..... Сум:..... Баг:.....
Малчны овог нэр:..... Утасны дугаар:.....
Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн нэр:.....



2024 он

ҮЗЛЭГ АНГИЛАЛТ ХИЙСЭН БҮРТГЭЛ, ТЭМДЭГЛЭЛ

№	МУТАУНэгжийн нэр	Үзлэг ангилалт хамрагдсан		Он, сар, өдөр	Баталгаажуулсан мал зүйчийн гарын үсэг
		Мал төрөл	Тоо		


Төрөл бүрийн малд үзлэг ангилалт хийж баталгаажуулах дэвтэр

6. Мал үржлийн албаны мэргэжилтэнгүүд санаачлан Адууны шүдний бодит үзүүлэнг /нас, насны адууны шүдий / хийж үзүүлбэрээр ашиглаж эхлээд байна .



Адууны шүдний үзүүлэн

7. Дэлгэрхангай, Дэрэн, Говь-Угтаал сумдын малчдын зөвлөгөөнд нийт 320 гаруй малчинд монгол улс, тэр дундаас Дундговь аймгийн нутаг бэлчээрт дасан зохицох чадвартай, нутгийн монгол малд сайжруулагчаар ашиглах боломжтой үүлдэр омгийн малын танилцуулга мэдээллийг танилцуулсан. Малын генетик нөөцийн тухай хуулинд 2023 оны 12 сард орсон заалтын өөрчлөлт шинэчлэлтийг малчидад танилцуулж, тооцох хариуцлагын хэм, хэмжээг танилцуулж, шинэлэг мэдээ, мэдээллээр ханган ажилласан.



8. Нутгийн монгол Ширгүүний говийн хонины генетик шинж чанарыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлохоор хийгдэж эхэлж буй анхан шатны дээж авах үйл ажиллагааг ХААИС-ийн багш нартай хамтран зохион байгуулсан.



ГАЗАР ТАРИАЛАНГИЙН САЛБАРТ

9. Сайнцагаан сумын Мөнгөлөг МД ХХК өвлийн хүлэмжний зориулалтаар 2023 онд Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 179.5 сая төгрөгний хөнгөлөлтэй зээлд хамдагдсан. Улмаар шинээр $10 \times 30 = 300$ м.кв хүлэмжинд хүнсний нарийн ногоо тариалж одоогийн байдлаар 0,35 тн өргөст хэмх хураан авч орон нутгийн зах зээлд нийлүүлээд байна.



10. Сайнцагаан сумын Арвин их сан ХХК жимс, жимсгэнийн тариалалтын зориулалтаар ЖДҮХСангийн 210.0 сая төгрөгийн хөнгөлөлтэй зээлд хамрагдсан Энэ онд шинээр 3 га талбайд алимны төгөл байгуулж, 4 төрлийн сортын алимны суулгац тариалаад байна.



11. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөн "Хүнсний хангамж аюулгүй байдал"-ын талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын 36-р тогтоолын хүрээнд улсын төсвийн 250,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрыг түшиглэн 3 га талбайд жимс, жимсгэний суулгац үржүүлгийн плантаци төв байгуулсан. Үржүүлгийн төвд улиас 175 ширхэг, хайлаас 700 ширхэг нийт 3 эгнээ 875 ширхэг хамгаалалтын ойн зурвас, 7 төрлийн жимс, жимсгэнийн суулгац 1500, нийт 2375 ширхэг суулгацыг суулган хүлээн авч, арчилж, услаж ургуулж байна. Нийт модны ургалт 50 хувьтай.



12. Сайнцагаан сумын иргэн С.Амарбаясгалан Бүгд найрамдах солонгос улсын технологиор барьсан 3 улирлын $280*4=1120$ м.кв хүлэмжинд эрт ургацын байцааг тариалж, одоогийн байдлаар 6тн байцааг ургац хураан авч орон нутгийн зах зээлд нийлүүлээд байна. Дээрх 3 улиралын хүлэмжийг хувийн хөрөнгө оруулалтаар буюу 250,0 сая төгрөгөөр барьж байгуулсан байна.



13. Сайнцагаан сумын иргэн Ч.Ихбаяр нь хувийн хөрөнгө оруулалт 110,0 сая төгрөгөөр шинээр 3 га талбайг хашаажуулж, Зуны 4 ш буюу 1400 м.кв талбай бүхий хүлэмжийг $(7*50=350\text{м}^2)*4=1400$ м2 барьж байгууллаа. Дээрх хүлэмжүүдэд тарвас, лооль, өргөст хэмхийг тариалсан. Мөн 2,3 га ил буюу гадаа талбайд эрдэнэ-шиш тариалах бэлтгэл ажил хийгдэж байна.



Мэдээ нэгтгэсэн: Мэргэжилтэн

Б.Дэлгэрмандах

**ТЭДГЭЭРИЙН ХҮРЭЭНД АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ
ҮР ДҮН**